



ХӨСӨГ ТРЕЙД

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 07 сар 16 өдөр

№

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“ХӨСӨГ ТРЕЙД” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 07-р сарын 16-ны өдрийн 10 цаг 00 минутад Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Сэнтрал тауэр, 902 тоот Хурлын танхимд хуралдуулав.

Хуралд:

- Эй Ди Эм Эм Ди ХХК 96,357 ширхэг хувьцааны саналаар, Итгэмжлэгдсэн төлөөлөгч Ж.Гантогтох /өөрийн биеэр/
- Д.Бадам 88,118 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- С.Жавзан-Орлом 54,311 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/
- Г.Маргад 53,916 ширхэг хувьцааны саналаар /өөрийн биеэр/ тус тус оролцож нийт 292,702 ширхэг хувьцаа буюу нийт гаргасан хувьцааны 98.9% хувийг эзэмшигчид хуралд оролцлоо.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд болох Т.Өлзийбүрэн, Р.Гансүх, Ц.Дамжин нар өөрийн биеэр оролцов.

Хурлыг компанийн ТУЗ дарга С.Болор удирдав.

Хурлаар:

- 1.1. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах /ердийн санал хураалт/;
- 1.2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдийг сонгох /кумулятив аргаар/;
- 1.3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгох /кумулятив аргаар/ асуудлыг хэлэлцэв.

Хурлын дарга С.Болор: Сайн байцгаана уу? Хурлын дэгийн дагуу тооллогын комисс ирцээ танилцуулаад хуульд заасан ирцийн шаардлага хангасан бол хурлаа эхэлье.

Тооллогын комиссын дарга Б.Гэрэлмаа хурлын ирцийг танилцуулан, Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав. Тооллогын комиссын тогтоолоос үзэхэд хурлын ирц 98.9% байгаа тул Монголын Улсын Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн

69.1-д заасны дагуу хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцож, хурлыг эхлүүлэх зөвшөөрлийг Хурлын даргад өгөв.

Хурал 10 цаг 10 минутад эхлэв.

СОНССОН НЬ :

Хурлын дарга С.Болор: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн дүрмийн зарим зүйл заалтад өөрчлөлт оруулах, ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох, ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох талаар хэлэлцэнэ. Хурал маань дэгийн дагуу үргэлжилнэ. Хэлэлцэх асуудлын дагуу эхлээд Компанийн дүрэмд орох өөрчлөлтийг танилцуулъя.

Хурлын дарга дүрэмд орох өөрчлөлтийг уншиж танилцуулав.

Хурлын дарга С.Болор: ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдийн мэдээлэл болон ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны шийдвэрийг танилцуулъя.

Хурлын дарга ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны шийдвэр, ТУЗ-ийн ердийн гишүүдэд нэр дэвшигчдийн мэдээллийг уншиж танилцуулав.

Хурлын дарга С.Болор: ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн мэдээлэл болон ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны шийдвэрийг танилцуулъя.

Хурлын дарга ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны шийдвэр, ТУЗ-ийн хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийн мэдээллийг уншиж танилцуулав.

Хурлын дарга С.Болор: Хурлаар хэлэлцэх зүйлсийг танилцууллаа. Хувьцаа эзэмшигч нараас асуух асуулт байвал нээлттэй асуугаад явъя.

Хувьцаа эзэмшигч Г.Маргад: Сайн байцгаана уу, ТУЗ-ийн гишүүд маань хэдэн жилээр томилогдож байгаа билээ.

Хурлын дарга С.Болор: Компанийн дүрэмд заасны дагуу 3 жилээр томилогдож байгаа.

Хувьцаа эзэмшигч Г.Маргад: За ойлголоо, өөр тодруулах зүйл байхгүй ээ, дүрмийн өөрчлөлтийг зөвшөөрч байна.

Хувьцаа эзэмшигч С.Жавзан-Орлом: Сайн байна уу, хурлын материалтай танилцлаа. Дүрэмд өөрчлөлт оруулахад татгалзах зүйлгүй. Харин ТУЗ гишүүд сонгогдсоны дараа ТУЗ хурлаа хийн ТУЗ-ийн дэргэдэх хорооны гишүүдийг томилох, даргаа сонгох болон бусад холбогдох ажлуудаа хийлгэхийг мөн сануулъя.

Хурлын дарга С.Болор: Таны саналыг хүлээн авлаа. Тогтоолдоо энэ агуулгыг оруулъя.

Хувьцаа эзэмшигч Д.Бадам: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Хурлын материалтай танилцсан нэмэлтээр асууж тодруулах зүйл байхгүй байна. Бусад хувьцаа эзэмшигч нартай санал нэг байна дэвшүүлсэн асуудлыг зөвшөөрч байна.

Хувьцаа эзэмшигч Эй Ди Эм Ди ХХК-ийн төлөөлөгч Ж.Гантогтох: Сайн байна уу, Миний хувьд мөн санал байхгүй ээ.

Хурлын дарга С.Болор: За, гишүүдийн саналыг хүлээн авлаа. ТУЗ-ийн томилогдсон гишүүдэд ТУЗ дарга, хорооны гишүүд болон холбогдох бусад ажиллагааг гүйцэтгэхийг даалгая. Өөр ойлгомжгүй асууж тодруулах зүйл байхгүй гэж ойлгоод санал хураалтаа эхлүүлэе. Саналаа хувьцаа эзэмшигч нар хэлэлцсэн асуудал тус бүрээр өгнө. Тооллогын комиссын дарга саналын хуудас хэрхэн бөглөх зааврыг хувьцаа эзэмшигч нарт танилцуулаад санал авч дууссаны дараа дүнгээ танилцуулна уу.

Хурал 30 минут завсарлаад тооллогын комисс саналаа хурааж, дүнгээ гарган уншиж танилцуулав.

Тооллогын комиссын дарга Б.Гэрэлмаа: Хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналын хуудасны дагуу дараах дүн гарч байна.

1. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн саналын тоо 292,702 ширхэг буюу хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар зөвшөөрсөн.
2. ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчдэд санал ирүүлсэн байдал:
Д.Бадам – 292,702
С.Бат-Өлзий – 292,702
С.Болор – 292,702
Ж.Гантогтох – 292,702
С.Жавзан-Орлом – 292,702
Г.Маргад – 292,702
3. ТУЗ-ийн хараат бус гишүүнд санал ирүүлсэн байдал:
Р.Гансүх - 292,702
Л.Даваажав - 292,702
Ц.Дамжин - 292,702

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төслийг хурлын дарга уншиж танилцуулан, хурлын материалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгүүлэхийг дурдав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ №1:

1. Энэхүү хурлаар хэлэлцсэн өөрчлөлтүүдийг дүрэмд оруулан Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлав.
2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг Гүйцэтгэх захиралд даалгав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ №2:

1. Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн ердийн болон хараат бус гишүүдийг дараах байдлаар томилж бүрэн эрхийн хугацааг 3 (гурав) жилээр тогтоов.

- 1.1. Ердийн гишүүд:
 - 1.1.1. Д.Бадам
 - 1.1.2. С.Бат-Өлзий
 - 1.1.3. С.Болор
 - 1.1.4. Ж.Гантогтох
 - 1.1.5. С.Жавзан-Орлом
 - 1.1.6. Г.Маргад
 - 1.2. Хараат бус гишүүд:
 - 1.2.1. Р.Гансүх
 - 1.2.2. Л.Даваажав
 - 1.2.3. Ц.Дамжин
 2. ТУЗ-ийн гишүүд томилогдсонтой холбогдуулан анхдугаар хурлыг 1 (нэг) сарын дотор хуралдахыг гишүүдэд даалгав.
 3. Хурлаар хэлэлцэх асуудлыг дараах байдлаар батлав.
 - 3.1. ТУЗ-ийн даргыг сонгох
 - 3.2. ТУЗ-ийн дэргэдэх хороодыг томилох
 - 3.3. Холбогдох журам, зааврыг хэлэлцэн батлах
 4. Хурал даргалах эрхийг хурал хуралдах үед ТУЗ-ийн гишүүдээс олонхын санал авсан гишүүнд олгов.
- Хурал 11 цаг 20 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА:

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



С.БОЛОР

Б.АНХБАЯР